



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/37

Жаргалтхаан сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.11, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 21 дүгээр зүйлийн 21.1, дэх хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/180 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт байгаа мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, паразиттах өвчнийг эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт боловсруулалт, лабораторийн шинжилгээнд хамруулах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал Ц.Ганбат, Б.Уранцэцэг, П.Жамбалдорж нарт тус тус хариуцуулсугай.


2.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг графикт хугацаанд нь малчин, мал бүхий иргэдэд шуурхай мэдээлж, зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн заавар журмыг баримтлаагүйн улмаас өвчин гарах нөхцлийг бий болгосон малчин мал бүхий иргэд холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянах, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн П.Батдуламд даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, явцын болон гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж, Засаг даргад танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГАНБАТ



Data (D:) /A4 zahiramj